



УЛААНБААТАР
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

1983 оны 2 дугаар

сарын 10 ны өдөр

Дугаар 25

Улаанбаатар

хот

ЗАРИМ ХОРООЛОЛД НИЙТИЙН БИЕ
ЗАСАХ ГАЗАР БАЙГУУЛАХ ТУХАЙ

Улаанбаатар хотын АДХ-ын 13 дахь удаагийн сонгуулийн зургадугаар чуулганы шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ НЬ:

1. Хотын төвлөрсөн хороололд нийтийн бие засах газар ихээхэн дутагдалтайг харгалзан хавсралтад дурдсан ашиглалтгүй байгаа зарим уурын зуухнуудыг 1983 онд багтаан нийтийн бие засах газар болгон өөрчилж ашиглалтад оруулахыг Барилга засварын нэгдсэн трест /н.Доржпүрэв/, Орон сууц, нийтийн аж ахуй удирдах газар /н.Мандах/-т даалгасугай.


2. Хотын зорчигч тээврийн төв буудлын дэргэд шинээр баригч нийтийн бие засах газрыг 1984 оны эхний хагас жилд багтаан барьж ашиглалтад оруулахыг Геологи уул уурхайн үйлдвэрийн яамны барилга угсралтын контор /н.Сономцэвээн/, Хотын барилга захиалагчийн товчоо /н.Гомбосүрэн/-д даалгасугай.

3. Нийтийн бие засах газруудын барилгад шаардагдах хөрөнгийг сугалааны хөрөнгөнөөс гаргаж санхүүжүүлэхийг санхүүгийн хэлтэс /н.Эрдэмбат/-т зөвшөөрсүгэй.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА *[Signature]* С.МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУУЛАГАТАЙ НАРИЙН
БИЛГИЙН ДАРГА *[Signature]* Ч.ЖАМБАЛ



ХОТЫН АЖ АХУЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
 ГААНЫ 1982 ОНЫ 2-р сарын
 25 дугаар
 ТОГТООЛН ХАВСРАЛТ

ХОТЫН ТӨВЛӨРСӨН ХОРООЛЛЫН
 БИЕ ЗАСАХ ГАЗРЫН ЖАГСААЛТ

Барилгын нэр	Байршилт /еөрчлөх уурын зуухны нэр/	Төсөвт өртөг /мян. төг- еөр/	Гүйцэтгэгч байгуулла- гын нэр	Захиалагч байгуул- лага	Ашиглалтад оруулах хугацаа
					он-ули- рал
I	2	3	4	5	6
1. Нийтийн бие засах газар	6-р халуун усны дэргэдэх уурын зуух	60,0	БЗН трест	ОСНААУТ	1983-IV улирал
2. "-	72-64 айлын орчны хорооллын уурын зуух	71,4	БЗНТ	ОСНААУТ	1983-IV улирал
3. "-	ТХ-60 айлын орчны хорооллын уурын зуух	63,8	БЗНТ	ОСНААУТ	1983-IV улирал
4. "-	1991 онд 45-р төстөөс хувируу 1,2-р 54 айлын хорооллын уурын зуух	54,8	БЗНТ	ОСНААУТ	1983-IV ул
5. "-	Зорчигч тээврийн төв буудлын дэргэд	122,5	ГҮҮҮ ЯАМНЫ БУК	ХОТЫН БЗ ТОВ- ЧОО	1984-II ул.
БҮГД		373,0			